

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН


Хамрагдах хугацаа: 2016.11.01-2017.06.15

Судалгаанд оролцогчдын тоо: 117'152 татвар төлөгч

Судалгааны арга, хэлбэр: www.e-tax.mn цахим хуудсаар татвар төлөгч татварын тайлангаа бөглөж явуулахын өмнө заавал бөглөх байдлаар байрлуулж авсан.


Санал асуулга: 19 асуулттай санал асуулга

Асуулт 1: Та хариуцлагын хэлбэрээ сонгоно уу?



Судалгаанд нийт 117'152 татвар төлөгч хамрагдсаны 71 хувь буюу 82'582 нь аж ахуйн нэгж, 11хувь буюу 12'559 нь хувиараа бизнес эрхэгч иргэн, 5 хувь буюу 6'001 нь төсөвт байгууллага, 5хувь буюу 6'382 нь төрийн бус байгууллага, 8хувь буюу 9'596 бусад хэлбэрийн байгууллагын төлөөлөл


хамрагдсан байна.



Асуулт 2: Татварын байгууллага танд түргэн, шуурхай, ил тод, хүнд сурталгүй үйлчилж чадаж байна уу?


Нийт санал асуулгад оролцогчдын 90 хувь буюу 104'921 нь тийм, 10 хувь буюу 12'191 нь үгүй гэсэн хариултыг өгчээ.

Асуулт 3: Татварын албанаас татвар төлөгчдөд үзүүлж буй үйлчилгээг хөнгөн, шуурхай болгохын тулд ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?



Татварын албанаас үйлчилгээг хөнгөн шуурхай болгохын тулд ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 44 хувь нь Татварын албанаас мэдээлэл, сурталчилгааг нэмэгдүүлэх, 40 хувь нь Татварын улсын байцаагчийн мэдлэг чадвар, ёсзүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх шаардлагатай гэж хариулжээ.

Асуулт 4: E-tax буюу шинэ цахим татварын мэдээллийн системээр тайлан гаргахад тулгарч буй хүндрэл бэрхшээлтэй асуудлууд юу байна вэ?




Дээрх асуултад 81 хувь буюу 94'734 татвар төлөгч цахим тайлангийн систем гацдаг, маш их ачаалалтай гэж хариулсан бол 22'373 нь хэрэглэхэд ойлгомжгүй, мэдэхгүй гэсэн байна.

Асуулт 5: Татварын хууль тогтоомжийн талаар мэдээ мэдээлэл, сурталчилгааг ямар хэлбэрээр авбал илүү үр дүнтэй байх вэ?



Татварын хууль, тогтоомжийн талаар мэдээлэл, сурталчилгааг ямар хэлбэрээр авбал илүү үр дүнтэй гэсэн асуултад оролцогчдын 23 хувь нь хууль, тогтоомжийн эмхэтгэл, гарын авлага байдлаар, 28 хувь нь e-tax.mta.mn, татварын албаны цахим хуудаснаас, 11 хувь нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр, 7 хувь нь социал медиагаар, 8 хувь нь татварын албаны сургалтаар, 6 хувь нь 1800-1288 лавлах утаснаас гэх мэтээр дээр дурдсанаар хариулжээ. Эндээс харвал татвар төлөгчид мэдээ, мэдээллийг цаг хугацаа, орон зай хэмнэсэн байдлаар интернет, утас, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан авах сонирхолтой нь харагдаж байна.


Асуулт 7: Та татварын албанаас зохион байгуулж байгаа ямар төрлийн сургалтанд хамрагдах сонирхолтой байна вэ?



Судалгаанд оролцогчдын 44 хувь нь татварын хууль, тогтоомжийн, 17 хувь нь нягтлан бодох бүртгэл, олон улсын стандартын, 17 хувь нь татварын тооцоолол, тайлангийн маягт, түүнийг бөглөх аргачлалын, 13 хувь нь цахим тайлангийн системийн сургалтад хамрагдах сонирхолтой байгаагаа илэрхийлжээ. Татварын албаны сургалт голдуу татварын хууль, тогтоомж, маягт түүнийг

бөглөхөд чиглэдэг бөгөөд цаашид цахим тайлангийн сэдвээр сургалтаа хийхээр төлөвлөнө.

Асуулт 8: Та өөрийн харилцдаг татварын албаны үйлчилгээг хэрхэн үнэлж байна вэ?




Татварын албаны үйлчилгээнд татвар төлөгчдийн 83 хувь нь хангалттай, сайн гэсэн бол 15 хувь нь дунд, 3 хувь нь буюу 2'409 татвар төлөгч хангалтгүй гэжээ.

Асуулт 8а: Хэрэв 8-р асуултанд хангалтгүй гэж хариулсан бол татварын албаны аль чиглэлийн үйлчилгээг сайжруулах саналтай байна вэ?




- 55 хувь нь Татвар төлөгчдөд үйлчлэх
- 22 хувь нь Хууль эрх зүй, татварын маргаан таслах.
- 17 хувь нь Татварын хяналт шалгалт
- 17 хувь нь Татвар хураах

Асуулт 9: Таны бодлоор татварын албаны үйл ажиллагаа хэр сайжирч байна вэ ?




Судалгаанд оролцогчдын 80 хувь нь хангалттай, сайн сайжирч байна гэсэн бол 18 хувь нь дунд, 2 хувь нь хангалтгүй гэжээ.

Асуулт 10: Та тайлангаа хугацаанд нь илгээдэг үү?



Оролцогчдын 58 хувь нь тайлангаа хугацаанд нь илгээдэг, 3 хувь нь үгүй, 39 хувь нь хариулаагүй байна.



Асуулт 12: Та татвараа хугацаанд нь төлдөг үү ?


42 хувь буюу 49'116 нь тогтмол хугацаандаа татвараа төлдөг, 18 хувь нь хугацаа хоцроож төлдөг, 1 хувь буюу 1'751 татвар төлөгч огт төлдөггүй гэж хариулжээ.

Асуулт 12а:Хэрвээ 12-р асуултанд хугацаа хоцроодог, огт төлдөггүйгэж сонгосон бол ямар нөхцөл шалтгаан нөлөөлдөг вэ ?



Ямар нөхцөл шалтгааны улмаас хугацаа хоцроож татвараа төлдөг, эсвэл огт төлдөггүй вэ гэсэн асуултад 103 татвар төлөгч санхүүгийн нөхцөл байдлаас болж, 82 нь бусад шалтгаанаар, 11 нь тайлагнахад хүндрэлтэй байдаг Хууль, эрх зүйн орчин гэж хариулжээ.


Асуулт 13:Та цахим төлбөрийн баримтын системд /www.ebarimt.mn/ холбогдсон уу?



Судалгаанд оролцогч татвар төлөгчдийн 50 хувь буюу 58'392 нь цахим төлбөрийн баримтын системд холбогджээ.


Харин 11 хувь буюу 13'316 нь холбогдоогүй байна.

Асуулт 14:Хэрэв цахим төлбөрийн баримтын системд холбогдсон бол төлбөрийн баримтыг нэгдсэн системд илгээхдээ бүртгэлийн ямар хэрэгслийг ашигладаг вэ?




Судалгаанд оролцогчдоос цахим төлбөрийн баримтын системд холбогдсон 13'249 татвар төлөгчийн 86,5 хувь нь ebarimt.mn ашиглан төлбөрийн баримт олгодог байна. Харин үлдсэн 13,5 хувь нь Пос терминал кассын машин ашиглаж худалдан авагчдад төлбөрийн баримт олгодог ажээ.

Асуулт 15: НӨАТ-ын хуулийнсугалаатай баримт олгох, 2% буцаан олголтын талаарх таны бодол?



Энэхүү асуултад 1'790 татвартөлөгч хариулсан бөгөөд 80 хувь нь зөв, 20 хувь нь буруу гэж хариулжээ.

Асуулт 16: НӨАТ-ын хуулийн дагуу олгох 2% буцаан олголтыг ямар хугацаанд буцаан авах хүсэлтэй байна вэ?



Асуултад хариулсан татвар төлөгчдийн 41 хувь нь 6 сараар, 37 хувь нь 1 жилээр, 22 хувь нь сар тутам худалдан авагчийн хувьд НӨАТ-ын буцаалтаа авах хүсэлтэй байгаагаа илэрхийлжээ.

Улаанбаатар хот, 2017.06 сар